

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 07 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2024 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага өнөөдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бие даасан 881 хуулиас 117 гаруй хуулийг үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зэрэг нийт 54 бодлогын баримт бичиг, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр /2017-2025/, Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр /2016-2024/, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр /2020-2024/, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр /2022-2030/ зэрэг нийт 7 үндэсний хөтөлбөр, нийт 23 хууль тогтоомж, 77 захиргааны байгууллагын үйл ажиллагаа төлөвлөгөө, хөтөлбөр, 18 захиргааны хэм хэмжээний акт, нийт 179 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолоор баталсан цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, 2017 оны “Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 76, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/262 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, түүнд нэмэлтээр орсон тушаал, шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажилласан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-үндэслэн цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

2. Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрүүл мэндийг хамгаалж, нийгмийн баталгааг хангана.

3. Цахим шилжилтэд манлайлж, үйл ажиллагаандаа технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээлчээр ашиглана. гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Мөн дээрх бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор нийт 5 зорилтын хүрээнд 62 ажил, арга хэмжээ

төлөвлөн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ оны хагас жилийн байдлаар 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 32, 70-90 хувьтай хэрэгжих шатандаа 23, 30-50 хувьтай буюу хэрэгжилт удаашралттай 5, хугацаа болоогүй 2 ажил, арга хэмжээ байна.

Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Дотоодын цэргийн штаб, Зөрчлийн хэрэг бүртгэх алба, Санхүү, ар талын алба, Урьдчилан сэргийлэх газар, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлуулсан нь байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, бэхжүүлэх чиглэлээр хийсэн томоохон ажил болсон.

Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, интернэт орчинд хохирсон иргэдийн хохирлыг хэрхэн царцаах талаар олон улсын туршлагыг судалж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төвийг нээж, үйл ажиллагааг эхлүүлснээр цагдаагийн байгууллага 300-400 хохирогчтой болсны дараа хэргийг илрүүлдэг байсан бол уг төв байгуулагдсанаар иргэдийг цахим гэмт хэргийн хохирогч болохоос өмнө, гэмт этгээдийн хууль бусаар олсон мөнгө, эд хөрөнгийг захиран зарцуулахаас өмнө илрүүлэх боломж бүрдсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас 2024 оныг “Ахлагчийн жил” болгон зарласантай холбогдуулан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 53 нэгжид “Ахлагчийн зөвлөл” байгуулж, “Ахлагчийн асуудал хариуцсан мэргэжилтэн” буюу тэргүүн болон сургагч ахлагч томилж ахлагч бүрэлдэхүүний бүтцэд анх удаа удирдах албан тушаалыг бий болгосон. Мөн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагчийн зөвлөл”-ийн ажиллах журам, ахлагчийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг тус тус боловсруулан баталж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Тухайн алба хаагчид үндсэн ажлынхаа хажуугаар нэмэлт чиг үүрэг гүйцэтгэхгүй, ахлагч бүрэлдэхүүний боловсролыг дээшлүүлэх, эрх ашгийг хамгаалах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн тодорхой ажлуудыг хариуцан гүйцэтгэх юм.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын мандаттай Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд 2006 оноос эхлэн оролцож, хүлээсэн үүргээ амжилттай гүйцэтгэж ирсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлаар “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталснаар дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад цагдаагийн баг бие даан оролцох эрх зүйн орчин бүрдсэн.

Хоёр. Хүний нөөцийн чиглэлээр

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч, хүний нөөцийн бодлого, алба хаагчаа бэлтгэж буй байдал, үр дүн, бүтэц, зохион байгуулалт, хууль, эрх зүйн орчны нийцэл, бодлого, үйл ажиллагааг тодорхойлж, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд ISO стандарт нэвтрүүлэх зэрэг 8 зөвлөмжийг хэрэгжүүлж байна.

Гурав. Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр

Алба хаагч өртөж, хохирсон тохиолдол бүрд хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, даатгалын байгууллагаас нөхөн төлбөр олгуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”, “Алба хаагч, ажилтны сургалт, ажиллах

нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг тус тус боловсруулан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 60 хоногийн хугацаанд “Алба хаагч-Таны төлөө” аяныг зохион байгуулж, харьяа нутаг дэвсгэрийн улсын болон хувийн эмнэлэгтэй хамтран 4306 алба хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн 45 анги, байгууллага “Сэтгэл тайван-Бие эрүүл алба хаагч” өдөрлөгийг зохион явуулж, давхардсан тоогоор 8425 алба хаагчид эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн байна.

Дөрөв.Ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр

Алба хаагчдын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, байгууллагын нууц, аюулгүй байдлыг хангах зорилгоор Хууль зүй, дотод хэргийн сайдын багц “Хөрөнгө оруулалт”-аар 810 ширхэг компьютер, 810 ширхэг принтерийг худалдан авч, хувийн компьютер, принтер ашиглаж байгаа хүрэлцээгүй газруудад олгох ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах, алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжирч, хэрэгцээтэй техник хэрэгслээр хангагдах, албан үүргээ хэвийн явуулах боломж бүрдсэн.

Иргэн, хуулийн этгээдээс цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийг хүлээн авах, дамжуулах, хэрэг учралын газарт очиж хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэрлэлтэд бүрэн хяналт тавих, шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах үүргийг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг 12 цаг үүрэг гүйцэтгэж 24 цаг амарч, 12 цаг үүрэг гүйцэтгэж 48 цаг амраах (12/24/12/48), 12 цаг үүрэг гүйцэтгэж 24 цаг амарч, 12 цаг үүрэг гүйцэтгэж 24 цаг амраах (12/24/12/24) цагийн хуваарьт шилжүүлэн ажиллуулж байна. Ингэснээр Хөдөлмөрийн тухай хуулийн 84.2 дахь хэсэгт “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна”, мөн зүйлийн 84.4 дэх хэсэгт “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй, өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” гэсэн заалтууд хэрэгжиж, алба хаагчдын ажлын ачаалал буурах нөхцөл боломж бүрдсэн.

Цагдаа, дотоодын цэргийн 27 анги, байгууллага 48 албан тушаалд ажлын байрны зураг авалт хийж, батлагдсан орон тоог газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, нягтаршилт, тээврийн хэрэгслийн өсөлт, бууралттай харьцуулан ажлын ачааллыг дүгнэж, “их ачаалалтай” дүгнэгдсэн ажлын байрны ачааллыг хөнгөвчлөх зорилгоор техник хэрэгслээр хангах, дотоод зохион байгуулалт хийх, шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тухайлбал, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас “их ачаалалтай” гэж дүгнэгдсэн Шуурхай удирдлагын хэлтсийн ахлах зохицуулагч ажлын байр (албан тушаал)-ны орон тоог нэмж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, дуудлага, мэдээллийн хяналтын хувийг нэмэгдүүлэх саналыг хүргүүлж, орон тоог 12-оор нэмэгдүүлж, нийт 24 орон тоотой болгож ажил, ачааллыг тэнцвэржүүлсэн.

Тав. Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр

Алба хаагчдын сурч боловсрох эрхийг хангах, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан “Цагдаа судлал” бүрэн дунд боловсролтой алба хаагчдад зориулсан хөтөлбөрт элсэн суралцах алба хаагчдыг суралцуулахдаа элсэлтийн ерөнхий шалгалтын оноог 480 байсныг 440 болгон бууруулж, 5 буюу түүнээс дээш бүтээлтэй ажилласан, 30-аас дээш насны алба хаагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтгүй элсүүлэн суралцуулахаар журамд нэмэлт оруулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн байгууллагаас бие даасан цагдаагийн баг оролцуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан. Цаашид энхийг сахиулах ажиллагаанд 160-170 хүний бүрэлдэхүүнтэй Цагдаагийн баг илгээхээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд алба хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, сургалтад хамрагдах хүсэлт гаргасан алба хаагчдын судалгааг гаргаж, 201 алба хаагчийг сонгон авч, 5 дугаар сарын 20-ны өдрөөс танхимын сургалтыг зохион байгуулж эхэлсэн.

Дотоодын цэргийн штабаас Бүгд Найрамдах Хятад Ардын Улсаас Монгол Улсад суугаа цэргийн атташетаг уулзалт зохион байгуулж, тус Улсын Батлан хамгаалах яамны харьяа сургуулиудад 5 алба хаагчийг суралцуулахаар бэлтгэж байна.

Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын мэргэжил, боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор Дотоод хэргийн их сургуульд “Цагдаа судлал”, “Цагдаагийн ажил-Эрх зүй” хөтөлбөрийн 3 болон 4, 5 жилийн эчнээ дамжаанд 68, Орхон их сургуулийн бакалаврын хөтөлбөрийн эчнээ сургалтад 62, Бүгд Найрамдах Турк Улсын Цагдаагийн академид 2, Эргийн хамгаалалтын академид 2, нийт 134 ахлагчийг суралцуулж байна.

Зургаа.Дэвшилтэд техник, технологийг үйл ажиллагаандаа ашиглах чиглэлээр

Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар 7, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Журам, аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад зааснаар цагдаагийн байгууллагаас 9 төрлийн лавлагаа, 5 үйлчилгээ, нийт 21 төрлийн лавлагаа, үйлчилгээг цахимаар тус тус үзүүлэхээр тусгагдсанаас хууль, тогтоол, журам зааснаар төрийн үйлчилгээний “Е-Монголиа” нэгдсэн системд 20 үйлчилгээ, лавлагааг холбож, хууль, тогтоолд заагаагүй боловч нэмэлтээр “Авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл лавлах”, “Галт зэвсгийн зөвшөөрөл”, “Иргэн болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдан авах тусгай зөвшөөрөл авах”, “Камерын хяналтын тодорхойлолт”, “Галт зэвсгийн сургалтад суусан тухай лавлагаа”, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын “Лавлагаа”, “Тодорхойлолт, баримтын хуулбар” зэрэг 2 багц, 7 үйлчилгээ, нийт 27 лавлагаа, үйлчилгээг тус тус холбож, иргэд цахимаар үйлчилгээ авах боломжтой болсон.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх “Цагдаа аппликейшн”-ыг бүтээж, программ хөгжүүлэлтийг гүйцэтгэж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг шийдвэрлэхэд “ECS” программ хангамжид хохирогч болон хүүхэд тус бүрд аюулын зэргийн үнэлгээ хийх, “Хур” системээр дамжуулан Иргэний бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган баталгаажуулах, холбогдогчийн өмнөх ял шийтгэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах боломжтой болгон шинэчилж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, иргэдэд жолоодох эрхийн үнэмлэхийг түргэн хугацаанд хэвлэж олгох боломжийг бүрдүүлэх зорилгоор “Нью компас” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, энэ оны 06 дугаар сарын 10-ны

өдрөөс 2 ширхэг жолоодох эрхийн үнэмлэх хэвлэх автомат киоскийг Тэнгэр худалдааны төв, Драгон төв дээр байршуулан туршилтаар ажиллуулж жолоодох эрхийн үнэмлэхийг хэвлэж олгох ажлыг зохион байгуулж байна.

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтарч иргэдэд “IMEI” дугаараар хайлт хийж алдагдсан болон гээгдүүлсэн гар утасны мэдээлэл авах боломжийг “Төрийн цахим үйлчилгээний EMонголиа” системд байршуулж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Цагдаагийн байгууллагын “Ял шийтгэлийн лавлагааны систем”-ээс гаргаж байгаа “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт”-ыг англи хэлээр олгох программ хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж, энэ оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах зориулалт бүхий гар утасны “TUSLAMJ” аппликейшныг “Hand Pro” компанитай хамтран AppStore, GooglePlay-д байршуулан, ашиглалтын туршилт хийх ажлыг зохион байгуулж байна.

“Police Sop” аппликейшнээс “АСАП” санд эрэн сурвалжлагдаж байгаа оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүдийн мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлэхээр тус программын шинэчилсэн хувилбарыг боловсруулан “Google Play Store”-т байршуулсан.

Гэмт хэрэг, зөрчлийн талаар 102 тусгай дугаарт гадаад хэлээр ирүүлсэн дуудлага, мэдээллийг “Ярих-Орчуулах” хэлбэрээр интернэттэй орчинд 134, интернэтгүй орчинд 20 гаруй улсын хэлийг бичиг болон зурган хэлбэрээр орчуулах гадаад улсын “Хэлмэрч” орчуулгын төхөөрөмжийг ашиглан Англи хэлээр ярьсан дуудлагыг Монгол хэлээр орчуулах туршилт хийж, цаашид дуудлага, мэдээлэл хүлээн авах үйл ажиллагаандаа ашиглах боломжтой болсон.

Нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглааны үеийн хэв журмын хамгаалалт, зохицуулалтыг газар дээрээс шууд дамжуулах технологийн шийдэл боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүллээ.

“Чимэгэ системс” ХХК-ийн “Чимэгэ протокол” программ хангамжийг Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр туршилыг хэрэгжүүлсэн.

Хөдөлгөөнт болон сумдын хэсгийн төлөөлөгчийн цагдаагийн байгууллагын сүлжээний холболтыг сайжруулж “ESET Protect Mobile Device Management” системийн клауд орчны 3 сарын туршилтын лицензийг авч, тохируулах ажлыг хийж байна.

“Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт”-ыг Англи хэлээр олгох программ хангамжийг нэвтрүүлсэн.

“E-Монголиа” системээс цагдаагийн эрх бүхий алба хаагч 90 төрлийн лавлагаа, мэдээллийг авч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашиглах боломжтой болсон.

Алдагдсан болон гээгдүүлсэн гар утасны “IMEI” дугаараар хайлт хийж мэдээлэл авах боломжийг “E-Монголиа” системд байршуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Долоо.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр

Хүлээн авч, шалгасан гомдол, мэдээлэл: Цагдаагийн байгууллага 2024 оны эхний 06 сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 161.983


гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 14.578 буюу 9.9 хувиар өсөж, гэмт хэргийн шинжтэй 54208 (33.5%), зөрчлийн шинжтэй 100.290 (61.9%) гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байна.

2024 оны 06 дугаар сард 7485 гомдол, мэдээлэл буюу нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 4.6 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг: Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 20507, Улаанбаатар хотод 14162 (69.1%), орон нутагт 6338 (30.8%), бусад газар (хилийн чанадад) үйлдэгдсэн 7 (0.1%) гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 1385 хэрэг буюу 7.2 хувиар;
- Нийслэлийн хэмжээнд 611 хэрэг буюу 4.5 хувиар;
- Орон нутгийн хэмжээнд 779 хэрэг буюу 14.0 хувиар тус тус өсөж,
- Бусад газар (хилийн чанадад)-т 5 хэрэг буюу 41.7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо (сүүлийн 10 жилээр)



Гэмт хэрэг үйлдсэн байдал: Бүртгэгдсэн гэмт хэргийн 3239 буюу 15.8 хувь нь согтуугаар, 2714 буюу 13.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 852 буюу 4.2 хувь нь бүлэглэн, 588 буюу 2.9 хувь нь хүүхэд оролцож, 915 буюу 4.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 4389 буюу 21.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн 3674 буюу 83.7 хувь нь залилах гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт: Улсын хэмжээнд 41.1 хувь, нийслэлд 35.8 хувь, орон нутагт 56.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 9.1 нэгжээр, нийслэлд 13.0 нэгжээр тус тус буурч, орон нутагт 1.8 нэгжээр өссөн байна.

Хэрэг бүртгэлтийн 18256 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1203 хэрэг буюу 7.1 хувиар өсөж, үүнээс 7508 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 1064 буюу 12.4 хувиар буурсан.

Нийт 10436 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1278 буюу 10.9 хувиар буурсан.

Холбогдогчдын 1929 буюу 18.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 679 буюу 26.0 хувиар, 737 буюу 7.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 3 буюу 0.4 хувиар тус тус буурсан байна.


Гэмт хэргийн улмаас 19647 иргэн, 69 хуулийн этгээд хохирч, үүнээс 478 хүн нас барж, 5249 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 901

буюу 4.8 хувиар, хуулийн этгээд 10 буюу 16.9 хувиар, гэмтсэн хүн 305 буюу 6.2 хувиар, нас барсан хүн 115 буюу 31.7 хувиар тус тус өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 290.7 тэрбум төгрөгийн хохирлын 89.0 тэрбум төгрөг буюу 30.6 хувийг нөхөн төлүүлж, 2681.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Зөрчил: Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 1.483.102 (Улаанбаатар хотод 1.039.811 буюу 70.1 хувь, орон нутагт 443.291 буюу 29.9 хувь) зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14066 буюу 1.0 хувиар, 1.478.069 зөрчлийг шийдвэрлэсэн нь 12341 буюу 0.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн зөрчлийн ангилал



Зөрчил гаргасан 1.441.277 иргэн, 20.621 хуулийн этгээдийг 37.5 тэрбум төгрөгөөр торгох, 6773 хүнийг баривчлуулах, 7965 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 1397 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулж, 36 хүнийг албадан сургалтад хамруулсан.

Улсын хэмжээнд 3743 (Улаанбаатар хотод 2300 буюу 61.4 хувь, орон нутагт 1443 буюу 38.6 хувь) хүн эрүүлжүүлж, 18766 хүнийг саатуулсан (Улаанбаатар хотод 14958 буюу 79.7 хувь, орон нутагт 3808 буюу 20.3 хувь) нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлсэн хүн 6594 буюу 63.8 хувиар буурч, саатуулсан хүн 8007 буюу 74.4 хувиар өссөн. Архины албадан эмчилгээнд 170 хүн, сайн дурын эмчилгээнд 124 хүнийг хамруулсан байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Зайнаас тандан судлах арга буюу сансрын хиймэл дагуулын суурь зургийг ашиглан хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг илрүүлэх зорилгоор өндөр нарийвчлал бүхий АНУ-ын Махаг, BlackSky хиймэл дагуулын байр зүйн зургуудыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй 312 аж ахуйн нэгжийн ашиглалтын 43105 га талбайд хяналт, шинжилгээ хийж, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн хууль бусаар ашигт малтмал олборлосон 9 аж ахуйн нэгжийн 129 га талбайг илрүүлж, мөрдөн шалгах ажиллагааг явуулж шийдвэрлүүлсэн.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд технологийн дэвшлийг нэвтрүүлж, алба хаагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор тээврийн хэрэгсэлд ачигдсан болон задгай талбайд хураасан мод, модон материалын эзлэхүүний хэмжээг интернэт, гар утасны сүлжээ хамаарахгүйгээр тодорхойлдог "Wood watcher" программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: “Нэг хороо-Нэг сар” нэгдсэн арга хэмжээг нийслэлийн 5 дүүргийн нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн гаралт ихтэй 12 хороог сонгон тухай орчинд үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийн оролцоо дэмжлэгтэйгээр 04 дүгээр сарын 22 өдрөөс 1 сарын хугацаатай камержуулах ажлыг зохион байгуулж, 2415 аж ахуйн нэгж, иргэний оролцоотойгоор 1629 камерыг шинээр суурилуулж, ажиллахгүй байсан 505 камерыг ажиллагаанд оруулж, 476 камерын чигийг ашигтай тусгалд тохируулж, 800 анхааруулах самбарыг гудамж талбайд байршуулах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Дээрх камеруудыг суурилуулснаар 1 иргэн 1000 метр замыг туулж өнгөрөхөд нэг хороонд 30-50 камерт өртөж, бичлэгт орох боломжтой болсон.

Цаашид Нийслэлийн хэмжээнд үлдсэн 167 хороог энэ оны 3, 4 дүгээр улиралд бүрэн камержуулж дуусгах, харин 21 аймгийг 334 сум, 208 багийг энэ оны 3, 4 дүгээр улирал болон 2025 оны 1, 2 дугаар улиралд бүрэн камержуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Бага насны хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, оюутан, сурагчид, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, далд хэлбэрт үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр улсын хэмжээнд “Нуугдмал” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Боловсролын ерөнхий газартай хамтран Өсвөр насны хүүхэд, залуучуудыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, тэдний хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Student” хэсэгчилсэн арга хэмжээг 2 сарын хугацаанд зохион байгуулж, нийслэл хотод байрлах 28 их, дээд сургуулийн 10,147 оюутанд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт 70 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, хүний амь, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч байгаа хохирол буурах эсэхэд дүгнэлт өгч, судалгааны материал бүрдүүлэн дүн шинжилгээ хийх замаар цаашид хэрэгжүүлэх ажлыг оновчтой тодорхойлох зорилгоор “Шугаман эргүүл, хар хэсэг” нөлөөллийн арга хэмжээг улсын хэмжээнд энэ оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна.

Нөлөөллийн ажлыг эхлүүлснээр олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто замд 43 хоногийн хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг 135 гэмт хэрэг бүртгэгдэж, 56 хүний амь хохирч, 139 хүн гэмтсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 19 нэгжээр буюу 12,3 хувиар, хүний амь хохирсон тохиолдол 15 нэгжээр буюу 21,1 хувиар, хүн гэмтсэн тохиолдол 21 нэгжээр буюу 13,1 хувиар тус тус буурсан үзүүлэлт гарлаа.

Гамшиг, аюулт үзэгдэл, хорио цээрийн дэглэм сахиулах ажлын талаар: Монгол орны ихэнх аймаг, сумдын нутгаар өвөлжилт хүндэрч, зудын гамшиг нүүрлэсэнтэй холбогдуулан Улсын онцгой комиссын энэ оны 01, 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтийг тус тус боловсруулан анги, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Улсын хэмжээнд цаг, агаарын аюулт үзэгдэл, малын гоц халдварт өвчний үед иргэдийг амь нас, эрүүл мэндээр

хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 371 алба хаагч, 104 автомашинтай, 4900 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, тухайн Аймаг, сумдын Засаг даргын захирамжаар бусад чиг үүргийн байгууллагуудтай хамтран хорио цээрийн дэглэм сахиулан ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн 8 дүүргийн 35 хорооны нутаг дэвсгэрт шар усны үер буух эрсэлтэй нөхцөл байдал үүсэж, 11269 айл өрхөд, шар усны үерээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл түгээх үед нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас 78 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Бүртгэл хяналтын талаар: Галт зэвсэг худалдан авах зөвшөөрөл авсан 418, Монгол Улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлсэн 30, жолоодох эрх сэргээсэн 20775, шинээр жолооч болж үнэмлэх олгогдсон 25838, ангилал ахиулсан 20640, жолооны 52827 үнэмлэх нөхөн олгосон. Мөн аюултай ачаа тээвэрлэх тухай аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх 1527 маршрутад 231 зөвшөөрлийг олгож, ажилласан байна.

Найм. Бусад чиглэлээр

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021-2030 онд “Нэг сая мод” тарихаар төлөвлөн, жил бүр тарьсан модны хувиар хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа бөгөөд 2021-2023 онд нийт 407 байршилд 212.653 мод тарьж, 106.3 га талбайг моджуулсан.

Энэ онд Цагдаа, дотоодын цэргийн 52 анги, байгууллагын 10036 алба хаагч хавар, намрын улиралд нийт 120.432 мод тарихаар төлөвлөж, хаврын мод тарих ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлигийн дагуу энэ оны 05 дугаар сарын 10-18-ны өдрийн хооронд зохион байгуулж, 7021 алба хаагч, өөрсдийн сонгосон 559 байршилд хайлаас, улиас, агч, гацуур, чацаргана, шинэс, бургас, нарс, голт бор, буйлс, бургас, жимсний мод зэрэг 14 төрлийн нийт 87.315 модыг тарьж, 43.6 га талбайг моджуулсан.

Мөн 642 алба хаагчийн хашаанд гацуур, шинэс, нарс, голт бор, агч зэрэг 11 төрлийн 9117 гоёлын модыг тарьж, мэдээллийг цахим хуудсаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан эко аялал, жуулчлалыг төлөвшүүлэх, байгальд ээлтэй хог хаягдалгүй аялах соёл, хэв маягийг хэвшүүлэх, иргэдийн буруу дадал хандлагыг өөрчилж, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлэх зорилгоор ухуулга, нөлөөллийн арга хэмжээг энэ оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд “Байгаль хамгаалал-2024” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх ажлын үр дүнд 153 байршилд үүссэн 206 тонн хог, хаягдлыг цэвэрлүүлж, 424 иргэн, 71 байгууллагад хог хаягдлын талаар ухуулга яриа хийж, 116 санамж, мэдээллийн самбар шинээр байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Нэгдсэн арга хэмжээний явц, үр дүнгийн талаар хэвлэлийн мэдээ бэлтгэн анги, байгууллагад хүргүүлж, хуваарийн дагуу төв, орон нутгийн 12 телевиз, 16 сайтад мэдээ, мэдээлэл өгч, ахуйн болон аюултай хог хаягдал, бусад төрлийн бохирдол /нүхэн жорлон/-оос сэргийлэх, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг бууруулах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 15 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээсэн нь 6451 хүнд таалагдаж 1646 хүн

сэтгэгдэл үлдээж, 1703 хүн бусадтай хуваалцаж, давхардсан тоогоор 1.065.964 хүнд хүрсэн.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор энэ оны 05 дугаар сарын 06-31-ний өдрийн хооронд “Хүн бүр мод тарьцгаая” мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, иргэд, олон нийтийг мод тарьж, ургуулахад уриалсан агуулга бүхий постер 20, видео 65, пост 16, рийл 42, нийт 135 контент байршуулан олон нийтэд түгээсэн нь 229.500 хүн дэмжиж, 5.010 хүн сэтгэгдэл үлдээж, 378,927 хүн бусадтай хуваалцаж, 20,393,154 хүний хандалт авсан байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР